



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 07 сарын 01 өдөр

Дугаар 4/417

Алтай хот

“Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газар” ААТҮГ-ын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны “Аймгийн 2022 оны төсвийн тодотгол батлах тухай” 37 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.2-т “Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газруудын удирдлага, менежментийг сайжруулна” гэсэн зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газар” ААТҮГ-ын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхээр батлагдсан 58,800,000 (тавин найман сая найман зуун мянга) төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Батзориг)-т зөвшөөрсүгэй.

2.Үйл ажиллагаанд зарцуулагдах хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж, үр дүнг тайлагнаж ажиллахыг “Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газар” ААТҮГ (М.Мягмарбаяр)-т үүрэг болгосугай.

3.Ажлын гүйцэтгэл, чанар, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Г.Хурцгэрэл), Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

C:/My documents/ZAHNR-3A-4 doc

0901791304